



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

Г Хорооны 2007 оны 156 дугаар тогтоолд Г
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 156 дугаар тогтоолын хавсралтын “Арилжаа, гүйлгээ хийгдсэн өдөр тутам /хувиар/” гэсэн 4 дэх багана, 1 дүгээр мөрний “1.а дахь хэсгийн “0.13” гэснийг “0.04” гэж өөрчилсүгэй.

2. Тогтоолын хавсралтад өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

3. Тогтоолын хавсралтад оруулсан өөрчлөлтийн хэмжээгээр зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2013 оны 3 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн тооцож, Хорооны дансанд төвлөрүүлж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, ”ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



000086